



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн

Т О Г Т О О Л

39

1958 оны 2 дугаар
сарын 28 -ны өдөр

Дугаар 36.

Улаанбаатар
хот

Аймаг, хотын гүйцэтгэх захиргаад
ажлын хувиарт зарим өөрчлөлт оруу-
лах тухай.

Орон нутгийн саналыг үндэс болгон, Б.Н.М.А. Улсын Сайд
нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Аймаг, хотын гүйцэтгэх захиргаад нийгэм-соёлын асуу-
дал эрхэлсэн орлогч даргын орон тоог хасаад, аймгуудад хөдөө
аж ахуй эрхэлсэн орлогч даргын орон тоог бий болгож, түүнд
хөдөө аж ахуйг удирдах бүх асуудлыг хариуцуулан, хөдөө аж
ахуйн хэлтсийн даргын үүргийг гүйцэтгүүлэхийн хамт, Улаан-
баатар хотын гүйцэтгэх захиргаанд худалдааны асуудал эрхэл-
сэн орлогч даргын орон тоог бий болгосугай.

Үүнтэй холбогдуулан, аймаг, хотын гүйцэтгэх захиргаад
соёлын хэлтсийн даргын орон тоог бий болгож, хөдөө аж ахуйн
хэлтсийн дарга, соёлын хэлтсийн орлогч даргын орон тоог хас-
сугай.

2. Аймгийн гүйцэтгэх захиргаад эрүүлийг хамгаалах хэлт-
сийн даргад аймгийн больницын эрхлэгчийн үүргийг хариуцуул-
даг, мөн хэлтсийн ариун цэврийн байцаагчид хэлтсийн орлогч
даргын үүргийг гүйцэтгүүлдэг явдлыг зогсоосугай.

Эрүүлийг хамгаалах хэлтсийн аж ахуй, санхүү эрхэлсэн
орлогч даргын орон тоог хасаж, аймгийн больницын эрхлэгч
бөгөөд ерөнхий эмчийн орон тоог бий болгосугай.

3. Аймгийн гүйцэтгэх захиргаад эрүүлийг хамгаа-
лах асуудал, хариуцлагатай нарийн бичгийн даргад соёл, гэгээр-

лийн асуудлыг эрхлүүлсүгэй.

4. Аймгийн гүйцэтгэх захиргаадад дежур 2-ын орон тоог 1958 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн бий болгосугай.

5. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны удирдах ажилтан нарын ажлын ерөнхий хувиарыг дор зааснаар тогтоосугай:

хотын гүйцэтгэх захиргааны дарга

а/хотын хэмжээний ажил, зохион байгуулалтын асуудлыг ерөнхийд нь удирдах ажил;

б/хот тохижуулах, барилгажуулах болон техникийн тусламжийн асуудал;

в/төсөв, санхүүгийн асуудал;

г/эрүүлийг хамгаалах ажил.

1-р орлогч дарга

а/хотын төлөвлөгөөний ажил;

б/хотын чанартай үйлдвэрийг удирдах асуудал;

в/хөдөө аж ахуйн асуудал.

хангамжийн аж ахуй эрхэлсэн

орлогч дарга

хотын орон сууц-хангамжийн аж ахуйг удирдах асуудал.

худалдаа эрхэлсэн орлогч дарга

хотын худалдаа, нийтийн хоолны трест, бэлтгэлийн конторыг удирдах асуудал.

хариуцлагатай нарийн бичгийн дарга

а/засаг захиргааны зохион байгуулалтын ажил;

б/ардын гэгээрэл, соёл, биеийн тамирын асуудал;

в/ардын цэрэг, иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх байгууллагын ажил.

6. Аймаг, хотын гүйцэтгэх захиргааны дарга, орлогч дарга, хариуцлагатай нарийн бичгийн дарга нарт үүрэг болгох нь:

а/ажлын энэ хувиарыг 1958 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн хийж, улс ардын аж ахуйг тодорхой, шуурхай удирдлагаар

хангах арга хэмжээ авсугай;

б/улс ардын аж ахуйг удирдах асуудлыг улам нарийн болгож, социалист хөдөө аж ахуй, соёлын байгуулалтыг эдийн засгийн мэдлэгтэйгээр төлөвлөгөө, тоо бүртгэлийн үндсэн дээр удирдах шинэ зорилтыг хангаж биелүүлсүгэй;

в/засаг захиргааны зохион байгуулалтын ажлыг улс ардын аж ахуйг хөгжүүлэхэд олон түмнийг зохион байгуулах дайчлан хөдөлгөх удирдлагын арга болгон сайжруулсугай;

г/аймаг, сумын нийт байгууллагын ажилд үнэн зөв мэдээ бүртгэлийн ролийг дээшлүүлж, мэдээ бүртгэлийн ажлыг баг, хориноос эхлэн эрс сайжруулахын хамт улсын төлөвлөгөө, төсөвтэй холбогдсон аж ахуйн ямар нэгэн асуудлыг гарцхүү үнэн зөв тооцооны үндсэн дээр шийдвэрлэж байдаг зарчмыг нэвтэрүүлсүгэй.

7.Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлийн 1955 оны 103 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн ,,а" ба 3 дугаар зүйл, Сайд нарын Зөвлөлийн 1956 оны 419 дүгээр тогтоолоор батлагдсан Улсын ариун цэврийн байцаан шалгах ерөнхий газрын дүрмийн 7 дугаар зүйлд ,,Аймгийн хөдөлмөрчдийн депутатын хурлын гүйцэтгэх захиргааны эрүүлийг хамгаалах хэлтсийн орлогч дарга нь аймаг дахь улсын ариун цэврийн байцаагч байх" гэсэн зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Б.Н.М.А.Улсын Сайд

нарын Зөвлөлийн
орлогч дарга

МОЛОМЖАМЦ

Б.Н.М.А.Улсын Сайд

нарын Зөвлөлийн Хэрэг

Эрхлэх Газрын дарга

БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн

эрхлэгч



О. Явдорж /ДАГВАДОРЖ/